



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

2024 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 04

Улиастай

Г Зөвлөмж хүргүүлэх тухай Г

Нэг Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл арга зүй

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Монгол Улсын хөгжлийн жилийн 2024 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны 3 дугаар улирлын байдлаар хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хяналтад авсан зүйл, заалт, хүрэх түвшинтэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн 3 дугаар улирлын байдлаар хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгосон.

Хяналтад авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ мөн журмын 6 дугаар бүлгийн 6.2, 6.3 дахь заалтын дагуу 5-н шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн www.unelgee.gov.mn цахим санд хууль тогтоомж, тогтоолын 36 шийдвэрийн 126 заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн орон нутагт даалгасан 17 арга хэмжээг нэгтгэн боловсруулж мэдээллийн санд оруулсан.

Хоёр. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

2024 оны 3 дугаар улирлын байдлаар 36 шийдвэрийн орон нутагт даалгасан 126 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд: Засгийн газрын тогтоол 67.23 хувь, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 75.2 хувь, Засгийн газрын

албан даалгавар 70 хувь, Ерөнхий сайдын захирамж 100 хувьтай тус тус хэрэгжиж аймгийн дүнгээр 71.38 хувьтай үнэлэгдсэн байна. Заалт тус бүрээр авч үзвэл:

100 хувь буюу Бүрэн хэрэгжсэн - 46 заалт

70 хувь буюу хэрэгжих шатанд - 49 заалт

30 хувь буюу хэрэгжилт хангалтгүй – 25 заалт

0 хувь хэрэгжээгүй - 3 заалт

Хэрэгжилтийн хугацаа тооцох боломжгүй - 3 заалт байна.

2024 оны 9 дүгээр сарын байдлаар дараах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

2022_402. Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-11-09 / ЗГ-ын тогтоол

Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт тус тус үүрэг болгосугай.

2022_419. Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-11-23 / ЗГ-ын тогтоол

3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга наарт даалгасугай

4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга наарт тус тус үүрэг болгосугай.

2023_63. Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологийг ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай / 2023-02-08 / ЗГ-ын тогтоол

3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сургийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт тус тус даалгасугай.

2023_68. Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2023-02-08 / ЗГ-ын тогтоол

7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

2023_344. Журам батлах тухай / 2023-09-13 / ЗГ-ын тогтоол

2. 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2023_458. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай / 2023-12-20 / ЗГ-ын тогтоол

2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах

2023_483. Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай / 2023-12-27 / ЗГ-ын тогтоол

2.8.. Иргэд орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүс нутгийг тодорхойлж, шаардлагатай газрыг чөлөөлж, олгох арга хэмжээ авч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймгийн Засаг дарга нарт;

2.9.. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

2024_77. Журам батлах тухай / 2024-02-28 / ЗГ-ын тогтоол

3. Энэ журмыг үйл ажиллагаандaa мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлagnадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”)

2023_39. 2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл / 2023-09-26 / 3Г-ын хуралдааны тэмдэглэл

XVIII.1.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжэн хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт;

2024_28. Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай / 2024-08-07 / 3Г-ын тогтоол

3.2.. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.3.. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурvas газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, гэрээний дагуу босоо чиглэлд отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;

4.. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

2024_215. Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай / 2024-05-15 / 3Г-ын тогтоол

4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Oosx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.

2023_49. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл / 2023-12-06 / 3Г-ын хуралдааны тэмдэглэл

XVI.5.2. Нөөцийн махны бэлтгэх, зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав

Хэрэгжилт нь хангалтгүй дээрх албан даалгавар, тогтоолуудын хэрэгжилтийг эрчимжүүлж, хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудтай ажлын уялдаа, холбоотой ажиллаж 2024 оны жилийн эцсийн тайланд тодорхой үр дүнд хүрч ажилласан байх шаардлагатай байна.

Гурав. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутагт холбогдолтой тусгагдсан 17 заалт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2024 оны 9 дүгээр сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нэгдсэн үнэлгээгээр 60 хувийн хэрэгжилттэй байна. Хэрэгжилт хангалтгүй дараах арга хэмжээ байна. Үүнд:

Эдийн засгийн бодлогын хүрээнд: “Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ” арга хэмжээний “Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамtran зохион байгуулна”

3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ” арга хэмжээний “2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.”

3.7.12.” Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.” арга хэмжээний “Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ”

Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд:

6.2.5. “Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.” заалтын “Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ” заалт .тус тус хэрэгжээгүй байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тодорхой ажил зохион байгуулан 2024 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг сайтар хянаж, тодорхой бичих шаардлагатай байна.

Цаашид хэрэгжүүлэх ЗӨВЛӨМЖ

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгаа тогтоолууд, хэрэгжээгүй бодлого зорилт арга хэмжээ болон тогтоол шийдвэрийн зүйл заалт бүрээр шалтгаан нөхцлийг судлан дүгнэлт хийж,

холбогдох арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнаж хэвших.

- Хэрэгжилт хангалтгүй байгаа хэрэгжээгүй зорилт арга хэмжээ болон тогтоол шийдвэрийн зүйл заалт тус бүр дээр төлөвлөгөө боловсруулж, удирдлагуудад танилцуулан, хамтран хэрэгжүүлэх хэлтэс, агентлаг, байгууллагуудтай нягт уялдаатай ажиллах (өмнөх хэрэгжилтээ хуулж тавихгүй байх)
- Арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилсан бэлтгэл ажлууд буюу тендер шалгаруулах, судалгаа шинжилгээ хийх, техник, эдийн засгийн үндэслэл, төсөв, зураг төсөл боловсруулах, хянах, концесс, гэрээ хэлцэл хийх, орон нутагт даалгасан яамтай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг холбогдох яамдад уламжлах зэрэг ажлыг шуурхай зохион байгуулах, энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах.
- Бодлого, арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч, төрийн захиргааны бусад байгууллагатай хэрэгжилтийн явц, үр дүнг хамтран хэлэлцэж, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тодорхой болгон, хэрэгжилтийг хангаж, хөрөнгө шаардлагатай арга хэмжээнүүдийг бодлогын баримт бичигт уялдуулан төлөвлөх.
- Тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, нотлох баримтад тулгуурласан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх.
- Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн тайлагналттай хамтатган дүгнэх болно.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.БЯМБАДОРЖ

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН *У.Дорж* Ц.ДҮҮРЭНБИЛЭГ